



МЭРГЭЖИЛТЭН СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн (ХААХОУС) санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил-нэмэлт санхүүжилт” (ЗЗБУХНС) төсөл Зах зээлийн хөгжлийн мэргэжилтэн шалгаруулж авна.

ЗЗБУХНС төсөл нь бэлчээрийн удирдлага, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хөдөөгийн бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид, иргэдийг дэмжих чиглэлээр 2018 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байна.

Мэргэжилтэн нь дараах үндсэн ажил үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төслийн зорилтууд, үйл ажиллагааг орон нутгийн удирдлагууд, бизнес эрхлэгчдэд танилцуулах;
- Бүх бичил, жижиг, дунд үйлдвэрүүдийн байршлыг тогтоох;
- Бизнес эрхлэгчдээс төслийн санал хүлээн авах ажлыг зохион байгуулах;
- Бизнес эрхлэгчдээс ирүүлсэн төслийн саналуудыг нягталж, төслийн хүрээнд дэмжлэг үзүүлэх боломжтой бизнес эрхлэгчдийн жагсаалт бэлтгэх;
- Сонгон шалгаруулах хороонд ажиглагчаар оролцох;
- Сонгогдсон аж ахуйн нэгжүүдэд зориулсан сургалтын эрэлт, хэрэгцээ тодорхойлох;
- Сонгогдсон нийт бизнес эрхлэгчдэд ерөнхий сургалт зохион байгуулах, аж ахуйн нэгж тус бүрийн шаардлагад нийцүүлсэн тусгайлсан сургалт зохион байгуулах;
- Аж ахуйн нэгжүүд бизнес төлөвлөгөө боловсруулахад нь зөвлөгөө өгөх Бизнес хөгжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг гэрээгээр ажиллуулах;
- Тухайн аж ахуйн нэгжид тулгарч буй бэрхшээлтэй асуудлууд (маркетинг, сав баглаа боодол, брэндинг, судалгаа, хөгжүүлэлт, үнэ, арилжааны сүлжээ, техникийн асуудал гм)-ыг шийдвэрлэхэд нь туслалцаа, зөвлөгөө үзүүлэх үйлчилгээ үзүүлэгч компаниудыг татан оролцуулах;
- Аж ахуйн нэгжүүдийн бизнес төлөвлөгөөг ХААХОУС болон арилжааны банкуудад танилцуулахаас өмнө нь хянан шинжилж бэлтгэх;
- Зээлийн батлан даалтын дэд нэгжийн Менежертэй хамтран бичил, жижиг болон дунд үйлдвэрүүдэд зориулсан зээлийн эх үүсвэрийг боломжит хэмжээнд, тогтвортой хүүтэйгээр, эргэн төлөлтийн хуваарийн дагуу бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан тооцоонд ашиглахаар тооцож олгох;
- Бичил, жижиг болон дунд үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжийн түвшинд тохирсон өөрчлөлтийг (үйлдвэрлэл, орлого, ашиг, хөрөнгө оруулалт, хөрөнгө, зах зээл, бүтээгдэхүүний төрөлжилт) хэмжих индикаторуудын жагсаалтыг Хяналт, үнэлгээний ажилтантай хамтран боловсруулах;

- ЗЗБУХНС төслийн зорилтот бүлгүүд болох эмэгтэйчүүд, малчдын бүлгүүдийг сонгогдсон аж ахуйн нэгжүүдийн нийлүүлэлтийн сүлжээнд үр дүнтэй оруулах чиглэлээр Зах зээлийн хөгжлийн дэд зохицуулагчтай нягт хамтран ажиллах;
- Зах зээлийн хөгжлийн дэд зохицуулагчид тогтмол тайлагнах, дэд бүрэлдэхүүн хэсгийн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг боловсруулах;
- Удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгавар

Тавигдах үндсэн шаардлага

- Бизнес, санхүү, нийгмийн хөгжлийн салбарын аль нэг чиглэлээр магистраас доошгүй зэрэгтэй;
- Зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр гадны тусламжаар хэрэгжсэн төсөл/хөтөлбөрүүдэд 3-аас доошгүй жил ажилласан байх;
- Хөдөөгийн бизнес хөгжүүлэлт, үйл ажиллагааны талаар туршлагатай байх;
- Иргэд, бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүд буюу зорилтот бүлгүүдтэй хамтран ажиллах, тэдэнд дэмжлэг, туслалцаа үзүүлэх талаар туршлагатай байх;
- Зээлийн бизнес төсөл унших, шинжлэх, бизнес төсөл боловсруулах чадвартай байх, банкны салбарт ажиллаж байсан бол давуу тал болно;
- Олон талт салбарын төлөөлөл бүхий багт ажиллах чадвартай байх;
- Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байхаас гадна төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хангаж ажиллах талаар туршлагатай байвал давуу тал болно.

Ажилд орох хүсэлт, холбогдох доорх материалыг 2019 оны 10-р сарын 31-ний өдрийн 17:30 цаг хүртэл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 601 тоотод хүлээн авна.

- Төрийн албан хаагчийн анкет
- Дэлгэрэнгүй намтар
- Өргөдөл
- Холбогдох баримт бичгийн хуулбар (Их сургуулийн диплом, иргэний үнэмлэх)